



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

**Чингэлтэй дүүргийн 18 дугаар цэцэрлэгийн  
балансаас хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,560,240.80 (гурван сая таван зуун жаран мянга хоёр зуун дөчин төгрөг наян мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн 18 дугаар цэцэрлэг (Д.Нарантуяа)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг (А.Алтанзая)-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг (А.Алтанзая)-т, Чингэлтэй дүүргийн 18 дугаар цэцэрлэг (Д.Нарантуяа)-т тус тус үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



115050000415

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын  
даргын 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн  
08 дугаар тушаалын хавсралт



Эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн 18 дугаар цэцэрлэг

| №   | Эд хөрөнгийн нэр       | Марк дугаар | Ашиглалтанд орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ     | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг  | Шилжүүлэн авах байгууллага           |
|---|------------------------|-------------|-------------------------|-------------|------------|-------------|--------------|-----------------------|--------------|--------------------------------------|
| Тавилга, эд хогшил                              |                        |             |                         |             |            |             |              |                       |              |                                      |
| 1   | Хүүхдийн хувцасны шкаф | ДСП         | 2018.11.05              | ширхэг      | 20         | 178,012.04  | 3,560,240.80 | 860,391.52            | 2,699,849.28 | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг |
| Нийт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн |                        |             |                         |             |            |             | 3,560,240.80 | 860,391.52            | 2,699,849.28 |                                      |